

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2026 оны 06 дугаар сарын 20

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлөөс 2026 оны эхний хагас жилийн байдлаар гүйцэтгэсэн ажлын товч тайланг танилцуулж байна.

Нэг. Сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалга:

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд улирлын дүнгээр салбар зөвлөлөөс 4 удаа удирдах 1, гүйцэтгэх 8 албан тушаалын сонгон шалгаруулалтын зарыг төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд 5-аас доошгүй хоног байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсаар “Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зар”-ыг нээлттэй байршуулсан.

Хүснэгт 1

№	Зар эхэлсэн, дууссан огноо	Орон тоо		
		удирдах	гүйцэтгэх	албан тушаалын нэр
1	2026.03.06 2026.03.11	-	5	ДоАГ-мэдээллийн технологийн мэргэжилтэн-1; ДоАГ-хяналтын улсын байцаагч-1; ХБГ-хяналтын улсын байцаагч-2; ЗБГ, Сүхбаатар аймаг дахь хэлтэс-хяналтын улсын байцаагч-1.
2	2026.03.30 2026.04.04	1	-	ХБГ, Хөвсгөл аймаг дахь хэлтсийн дарга-1.
3	2026.04.16 2026.04.21	-	2	ДоАГ-мэдээллийн технологийн мэргэжилтэн-1; ӨБГ- төсөв, санхүү хариуцсан ахлах мэргэжилтэн-1.
4	2026.04.17 2026.04.22	-	1	ӨБГ- хяналтын улсын байцаагч-1.
ДҮН		1	8	

Дээрх зарын дагуу 16 иргэн shalgalt@immigration.gov.mn цахим хаягаар шилжин ажиллах хүсэлт ирүүлснээс Төрийн албаны тухай хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан төрийн жинхэнэ албан хаагч бүртгүүлээгүй.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд салбар зөвлөлийн 13, 14, 19 дүгээр тогтоолоор байгуулсан сонгон шалгаруулалт зохион байгуулах тусгай шалгалтын комиссын хурлаар төрийн жинхэнэ албан хаагчдаас нөхөгдөөгүй нийт 9 албан тушаалын сул орон тооны захиалгыг салбар зөвлөлийн 3 удаагийн албан бичгээр болон se-admin.csc.gov.mn цахим системд ирүүлсэн захиалгыг хянаж, илгээсэн.

Хүснэгт 2

№	Албан бичгийн огноо, дугаар	Орон тоо		
		удирдах	гүйцэтгэх	албан тушаалын нэр
1	2026.03.12 №01	-	5	ДоАГ-мэдээллийн технологийн мэргэжилтэн-1;

				ДоАГ-хяналтын улсын байцаагч-1; ХБГ-хяналтын улсын байцаагч-2; ЗБГ, Сүхбаатар аймаг дахь хэлтэс- хяналтын улсын байцаагч-1.
2	2026.04.07 №02	1	-	ХБГ, Хөвсгөл аймаг дахь хэлтсийн дарга-1.
3	2026.04.23 №03	-	3	ДоАГ-мэдээллийн технологийн мэргэжилтэн-1; ӨБГ- төсөв, санхүү хариуцсан ахлах мэргэжилтэн-1; ӨБГ- хяналтын улсын байцаагч-1.
ДҮН		-	8	

Хоёр. Албан тушаалын тусгай шалгалт:

Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn цахим хуудсаар нээлттэй зарлуулсан төрийн тусгай гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо нөхөх 5 удаагийн тусгай шалгалт зохион байгуулж, 22 сул орон тоонд 69 иргэн бүртгүүлэн шаардлага хангасан 22 иргэн шалгалтад орж, 17 орон тоо буюу 77.2 хувийг нөхсөн, 5 буюу 22.7 хувь нь нөхөгдөөгүй.

Тусгай шалгалтад тэнцсэн иргэдийн 1 буюу 5.8 хувийг төрийн жинхэнэ албан хаагч, 5 буюу 29.4 хувийг төрийн албанаас түр чөлөөлөгдсөн иргэний нөөц, 11 буюу 64.7 хувь нь 2024-2026 оны төрийн албаны ерөнхий шалгалтын нөөцөд бүртгэлтэй иргэн байна.

Хүснэгт 3

№	Огноо	тоо		сул орон тоог		Тайлбар
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	Нөхсөн	Нөхөөгүй	
1	2026.01.13	-	10	8	2	Шаардлага хангасан иргэн бүртгүүлээгүй-2
2	2026.01.15	-	3	3	-	-
3	2026.04.08	-	5	4	1	Шаардлага хангасан иргэн бүртгүүлээгүй-1
4	2026.05.01	1	-	1	-	-
5	2026.05.22	-	3	1	2	Шаардлага хангасан иргэн бүртгүүлээгүй-2
ДҮН		1	21	17	5	

Салбар зөвлөлийн өмнөх оны 12 дугаар сарын 12, 17-ны өдрийн 13, 14, энэ оны 13, 14, 19 дүгээр тогтоолоор байгуулсан тусгай шалгалтын комиссын дүгнэлтийг үндэслэн Мэдээллийн технологийн хэлтэст 2, Дорноговь аймаг дахь газарт 2, Өмнөд бүс дэх газарт 2, Баруун бүс дэх газарт 1, Хойд бүс дэх газарт 7, Зүүн бүс дэх газарт 3, нийт 17 албан тушаал (1 хэлтсийн дарга, 2 ахлах мэргэжилтэн, 2 мэргэжилтэн, 12 хяналтын улсын байцаагч)-д салбар зөвлөлийн тогтоолоор тус тус нэр дэвшүүлж, тухайн албан тушаалд томилсон.

Тайлант хугацаанд сонгон шалгаруулалтын бүртгэл, шалгалтын явц, дүнд холбогдуулан ирүүлсэн өргөдөл, гомдол байхгүй.

Гурав. Бусад үйл ажиллагаа:

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг салбар зөвлөлийн 02 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаар хурлаар хэлэлцүүлэн зөвлөлийн ажиллах журмын 4.1.1-4.1.8-д заасан зорилтын хүрээнд 17 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 12 дугаар тогтоолоор батлуулсан.

Төрийн албаны зөвлөлийн 01 дүгээр сарын 08-ны өдрийн 04/36 албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан, “Төрийн байгууллагын 2025 оны чадахуйн зарчмын хэрэгжилт үнэлэх шалгуур”-ын биелэлтийг нэгтгэн байгууллагын даргын 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/136 албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газарт хүргүүлсэн. Мөн үйл ажиллагааны тайлангийн хавсралт нотлох баримтыг хариуцсан албан хаагчийн цахим хаягаар хүргүүлсэн.

Засгийн газрын 2025 оны “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 23 дугаар тогтоолын дагуу Гадаад харилцааны яамны төрийн нарийн бичгийн даргын ахалсан Төрийн албаны зөвлөлийн Захиргаа, удирдлагын газрын дарга, Архивын ерөнхий газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга болон улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 01 дүгээр сарын 15-20-ны өдрүүдэд “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг”-ээр байгууллага дээр ажилласан.

Үзлэгийн хүрээнд Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтэд хамаарах 2020-2025 оны баримт бичиг, төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдэл, салбар зөвлөл, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг шалгуулж, 92 хувьтай үнэлэгдсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2025 оны “Журам шинэчлэн батлах тухай” 521 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын 4.1.3-т “энэ журмын 3.1-д заасан албан хаагч өөрчлөгдсөн тохиолдолд цаасан хувийн хэргийг хүлээлцүүлэхэд хяналт тавих” гэж заасны дагуу Захиргаа, удирдлагын газрын хувийн хэрэг хариуцсан хүний нөөцийн мэргэжилтэн өөр нэгжид шилжихтэй холбогдуулан төрийн албан хаагчийн хувийн хэргийн тооллогыг 02 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Тооллогод төв болон хилийн боомт, орон нутаг дахь 19 нэгжийн 286 албан хаагчийн хувийн хэргээс жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөөтэй албан хаагчийн оронд түр орлож байгаа 7, шинээр томилогдсон төвийн 2, орон нутгийн 1, нийт 10 албан хаагчийн хувийн хэргийг хамруулаагүй бөгөөд 276 албан хаагчийн 32473 хуудас баримт бичгийг тоолж, дүнг 02 дугаар сарын 11-ний өдрийн 01-02/12 илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулсан.

Стандарт хэмжил зүйн газрын даргын 2025 оны С/12 дугаар тушаалаар баталсан “MNS 7068:2025, Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага, стандарт”-ыг үндэсний стандартаар шинээр баталсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2025 оны “Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага, стандартын хэрэгжилтийг хангах тухай” 318 дугаар тогтоолын 1.2-т “байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, төрийн байгууллагаас

үзүүлэх үйлчилгээнд тавигдах шаардлага болон дотоод журмыг “Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага, стандарт”-д нийцүүлэн шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулан баталж, мөрдөх” гэж заасны дагуу байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын нийцлийг тодорхойлох судалгааг 03 дугаар сарын 12-20-ны өдрүүдэд хийсэн.

Уг стандартын төрийн байгууллагад, төрийн албан хаагчид, төрийн байгууллагын үйл ажиллагаанд, үйлчилгээнд гэсэн 4 үндсэн шаардлагад хамаарах 19 дэд бүлэг, 66 заалтаас дотоод журамд зохицуулсан, нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх, нийцлийг тодорхойлсон дүнг нэгтгэсэн. Харьцуулсан судалгаагаар дотоод журамд шинээр 17, нэмэлт өөрчлөлтөөр 4 заалт оруулахаар санал боловсруулж, 03 дугаар сарын 23-ны өдрийн 01-02/27 илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2023 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор 41 дүгээр зүйлийн 41.20-д “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажилласан нэг жилийг нэг жил гурав сар ажилласанд тооцох ...”-той холбоотой зохицуулалтыг тусгаж, 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөд үүссэн асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор төрийн албан хаагчдын эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр хууль тогтоомжийн уялдаа, хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах 2 саналын томьёоллыг боловсруулж, байгууллагын даргын 03 дугаар сарын 16-ны өдрийн 01/501 албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн.

Засгийн газрын 2026 оны “Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 119 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд агентлагийн төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо болон хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэгт мандатын шинжилгээ, RACI матриц болон Function-Structure matrix аргачлалын дагуу хийж, 01/670, 01/794, 02/989 албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тус тус хүргүүлсэн.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛ